

“ФИЛОСОФИЧИД ГЭРЭЛ ЗУРГИЙН ДУРАНД” ГЭРЭЛ ЗУРГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

2023.06.03

Уралдааны зорилго: Монгол дахь философийн багш, судлаачдын амьдрал, үйл ажиллагааг гэрэл зургийн агшинд буулгаж, судалгаа, сурталчилгааны бүтээлд ашиглах.

Агуулга нь:

- Философийн багш, судлаачид ажлын байр болон чөлөөт цаг, нөхдийн дунд
- Тэдний нийгмийн болон мэргэжлийн үйл ажиллагааны оролцоо, идэвх гэх мэт.

Уралдааны үргэлжлэх хугацаа: 2023 оны 06.05-11.01 хүртэл үргэлжилж, 11-р сарын 05-ны дотор оролцогчдын материалыг mongolia.philosophy@gmail.com и-мэйл хаягаар хүлээн авна.

Уралдааны хамрах хүрээ: Философийн багш, судлаач, философи болон гэрэл зураг сонирхогчид.

Гэрэл зургийг илгээхэд анхаарах зүйлс:

- Гэрэл зургийн сэдэв агуулгын хүрээнд хүлээн авна.
- Гэрэл зурагт нэр өгсөн байх ба тайлбарыг товч, тодорхой, ойлгомжтой бичсэн байна.
- Гэрэл зургийг 30x20 см DPI-300 хэмжээтэй бэлтгэж, mongolia.philosophy@gmail.com и-мэйл хаягаар, мэдээллийн хуудасны хамт илгээнэ. Агуулга өөр 3-аас дээш тооны зураг байна.
- Мэдээллийн хуудаст: Зурагчны нэр, зургийн нэр, зургийн тайлбар, хугацаа, холбоо барих и-мэйл хаяг ба утасны дугаарыг бичсэн байна.
- JPG формат руу хөрвүүлсэн байх шаардлагатай. Компьютер дээр шалгахад эх зургийн танилцуулга буюу хэзээ, ямар камераар авсан тухай мэдээлэл байх ёстойг анхаарна уу.

Зохиогчийн эрх:

- Уралдаанд ирүүлсэн зургийг буцааж олгохгүй бөгөөд зохион байгуулагчдын гэрэл зургийн сан хөмрөгт зохиогчийн эрхтэй үлдэнэ. Ашиглах тохиолдолд зурагчны нэрийг заавал дурдана;
- Зургийг бусад хувь хүн, байгууллагад худалдан ашиглуулахгүй байх үүргийг зохион байгуулагч тал хариуцна;
- Цаашид ном, сэтгүүлд хэвлэх, сурталчилгааны ажилд ашиглах эрх нь зөвхөн МФХ-нд байхыг оролцогч зөвшөөрөх бөгөөд энэ талаар зурагчнаас тусгайлан зөвшөөрөл авахгүй;

Уралдааныг сурталчлах зорилгоор гэрэл зургийг сонин хэвлэл, вэб сайт, цахим хуудсанд нийтлэх, гэрэл зургийн үзэсгэлэн гаргахыг уралдаанд оролцогчид зөвшөөрнө.

Уралдааны нөхцөл ба шалгаруулалт:

- Зургийн зохиомж, агуулга, нэр, тайлбар, тухайн бүтээл чанарын шаардлага хангасан эсэх, оролцогчийн ур чадварыг харгалзан шүүнэ;
- Гэрэл зураг нь эх хувиар байх ёстой ба засвартай зургийг хүлээн авах боломжгүй;
- Зөвхөн оролцогчийн авсан гэрэл зураг байх ёстой бөгөөд зохиогчийн эрхийн асуудал үүссэн тохиолдолд зохион байгуулагч тал хариуцахгүй;
- Фокусгүй гэрэл зургийг хүлээн авахгүй;
- Гэрэл зургийг шүүгчдийн бүрэлдэхүүний дүнгээр шалгаруулна. Уралдааны эхний шалгаруулалтыг хийж 7 хоногийн дараа мэдэгдэнэ.

Гэрэл зургийг дараах үзүүлэлтээр шалгаруулна. Үүнд:

- Гэрэл зургийн сэтгэмж ба зурагчны ур чадвар
- Гэрэл зургийн чанар ба техникийн бусад үзүүлэлт
- Агуулга ба нэр, тэдгээрийн шүтэлцээ

Шагнал: Дэлхийн философийн өдөр гардуулна.

1-р байр 1 хүн: Өргөмжлөл, мөнгөн урамшуулал

2-р байр 1 хүн: Өргөмжлөл, мөнгөн урамшуулал

3-р байр 1 хүн: Өргөмжлөл, мөнгөн урамшуулал

Зохион байгуулагч: Монголын Философийн Холбоо

Холбоо барих:



Mongolian Philosophical Association МФХ
mongolia.philosophy@gmail.com